

О.Оюунжаргал, ДХИС-ийн Удирдлагын академийн
8052 дугаар дамжааны магистрант, ахмад
Г.Наранбаяр, ДХИС-ийн Удирдлагын академийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн удирдлага стратеги багийн ахлах багш,
хошууч

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ ЗАРИМ АРГА ЗАМ

Хураангуй: Энэ илтгэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн нэг үндсэн үүрэг болох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, тэр дундаа захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг судлан, дүгнэлт-санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Захиргааны хэргийн шүүх, шүүхийн шийдвэр, захиргааны байгууллага, албан тушаалтан, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, иргэн, хуулийн этгээд, эрх, ашиг сонирхол.

Оршил: 1940 оны Үндсэн хуулиар захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрт гомдол, нэхэмжлэл гаргах иргэний эрхийг анх удаа хуульчлан баталгаажуулж, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулжээ¹.

Монгол Улсын Үндсэн хуульд “...эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно”² гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 96 дугаар зарлигаар захиргааны хэргийн дагнасан шүүхийг анх байгуулснаас хойш өдгөө 16 жилийн хугацаа өнгөрчээ. Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, шийдвэрийг ийнхүү дагнасан шүүхийн хяналтад оруулснаар тэдгээрийн дур зоргын үйлдлээс иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх нөхцлийг бүрдүүлсэн юм. Жилээс жилд захиргааны хэргийн шүүхэд хандах иргэд, хуулийн этгээдийн тоо өсөн нэмэгдсээр байгааг шүүхээс гарч буй шийдвэрийн чанартай холбон тайлбарлаж болох ч гарсан шийдвэрийн хэрэгжилт урвуу хамааралтай байх аваас шүүхэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр хандсаны, шүүхээс маргаан хянан шийдвэрлэсний ач холбогдол, үр дагаврыг үгүйсгэнэ.

¹Б.Алтангэрэл, А.Намсаманд нар.Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтн. УБ.. 2020. 70 дахь тал

² Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. №1

Үндсэндээ иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг цаасанд буусан шүүхийн шийдвэрээр бус харин амьдралд бодитоор хэрэгжүүлэх, гарсан шийдвэр болгон ягштал хэрэгжих тийм л эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлага болжээ.

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, тулгамдаж буй асуудал

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд төгсгөлийн шат юм¹ гэж зарим судлаачид үзсэн байдаг ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, нөгөө талаар иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэхэд чиглэгдсэн онцгой эрх зүйн зохицуулалттай, бие даасан харилцаа юм гэж тодорхойлж болохоор байна.

Судалсан 3 жилийн хугацаанд улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүх нийт 5127 хэрэг шийдвэрлэсний 57.9% нь буюу 2969 хэргийг нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн талд шийдвэрлэсэн байна².

Зураг 1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 3 жилийн шүүн таслах ажиллагааны судалгаа




Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан

Захиргааны хэрэгт хариуцагчаар татагдсан төрийн захиргааны байгууллагын 3 жилийн судалгаанаас үзэхэд бүх шатны Засаг дарга нар болон Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг хамгийн олон удаа хариуцагчаар татагдсан байна. Үүнээс үзэхэд төрийн улс төрийн болон захиргааны албан тушаалтнууд илүүтэйгээр иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргадаг нь харагдаж байна.

¹ Д.Лхагвасүрэн, Д.Эрдэнэтуяа. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2016. 51 дэх тал

² Монгол Улсын шүүхийн 2019 оны шүүн таслах ажиллагааны тайлан



Нотолгооны үүргийг хэргийн оролцогч бус өөрөө дагнан гүйцэтгэдэг захиргааны хэргийн шүүхийн тухайд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа багагүй хугацаанд үргэлжилдэг. Төдийлөн элбэг биш ч зарим тохиолдолд маргааны ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалан хэдэн жил үргэлжлэх явдал гардаг байна. Гэвч энэ бүхний эцэст шүүхээс гарсан шийдвэр хэлбэрэлтгүй хэрэгждэг байх нь чухал юм. Зарим тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шүүхийн процессын хугацаанаас ч удаан үргэлжлэх, цаашлаад биелэгдэхгүй байх тохиолдол гарсаар байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулна гэж заасан.

Захиргааны хэргийн шүүхээс дээр дурдсан тооны хэрэг маргааныг шийдвэрлэсэн байгаа ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албадан гүйцэтгүүлэхээр сүүлийн 3 жилийн байдлаар 7.2 тэрбум төгрөгийн 1617 гүйцэтгэх хуудас бичигдэж ирсэн байна.

Хүснэгт 1. Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээ

Үзүүлэлт		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Биелэлтийн хувь
2017 он	гүйцэтгэх хуудас	395	258	137	65.3%
	мөнгөн дүн сая.төг	683.4	491.8	191.6	72.0%
2018 он	гүйцэтгэх хуудас	691	426	265	61.6%
	мөнгөн дүн сая.төг	1587.4	883.7	703.7	55.7%

2019 он	гүйцэтгэх хуудас	531	297	234	55.9%
	мөнгөн дүн сая.төг	4882.9	1071.9	3811.0	22.0%
3 жилийн байдлаар нийт	гүйцэтгэх хуудас	1617	981	636	60.7%
	мөнгөн дүн сая.төг	7153.7	2447.4	4706.3	34.2%

Дээрх 3 жилийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээнээс харахад нийт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 75.9 хувийг иргэний хэргийн шүүхийн шийдвэр, 20.3 хувийг эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр төлбөр гаргуулах, **1.8 хувийг захиргааны хэргийн**, 2.0 хувийг эрх бүхий бусад байгууллагын шүүхээр баталгаажсан шийдвэр эзэлж байна.


Хэдийгээр захиргааны хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагааны тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа боловч нийт шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эзлэх хувь (2013-2015 оны байдлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны 3.0 хувийг захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичиг эзэлж байсан¹) багасч байгаа нь иргэний болон бусад хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ихэссэн мөн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр албадлага хэрэглэсэн ч биелдэггүй, адгийн зарга арав хоног гэгчээр цаг зав үрсэн дэмий хэрэг болно гэж иргэд халширсантай холбоотой ч байж болох юм.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь: Иргэн, хуулийн этгээд буюу тэгш эрхтэй талуудын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаан байдаг бол, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь: Нэг талаас заавал төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан оролцож, тэдгээрийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой байдгаараа ялгаатай. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхдээ шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан нийтийн эрх зүйн шаардлагыг төрийн албадлагын үндсэн дээр хэрэгжүүлдэг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэж буй маргааны төрлөөр нь авч үзвэл газрын асуудал шийдвэрлүүлэх, тусгай зөвшөөрлийн эрх олгох, өргөдөл хүлээн авч шийдвэрлэх, ажилд эгүүлэн томилох, захиргааны акт хүчингүй болгосон, захиргааны байгууллагаас зохих акт гаргахыг даалгасан, актын биелэлтийг түдгэлзүүлж, энэ хугацаанд дахин шинэ акт гаргахыг даалгасан зэрэг маргаан байна.

¹ Ч. Өнөрцэцэг. Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл-// Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал онол, арга зүйн сэтгүүл. УБ., 2016. №2

Зураг 3. Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн маргааны төрөл



Эх сурвалж: Захиргааны хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан

Шийдвэр гүйцэтгэх албаны захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой 2017-2019 оны ажлын үзүүлэлтээс харахад 1617 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсаны дийлэнх нь ажилд эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгуулах, газрын маргаан, захирамж, акт хүчингүй болгох, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, тендертэй холбоотой ажиллагаа байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүгч гаргаж буй шийдвэртээ түүнийг гүйцэтгэх арга, журмыг тодорхойлж байхаар заасан¹ байдаг боловч төдийлөн хэрэгждэггүй нь Шийдвэр гүйцэтгэх газарт ирж буй гүйцэтгэх баримт бичгээс харагдаж байна. Шийдвэрийн тогтоох хэсэгт тухайн шийдвэрийг биелүүлэхэд ямар нэгэн хүндрэл учруулахгүй байхад онцгой анхаарвал зохино². Шүүхээс гарч буй шийдвэр хэрэгжих боломжтой, түүнд хэрэгжүүлэх арга замыг тодорхой заасан байх нь тухайн шийдвэр биелэгдэх анхдагч нөхцлийг бүрдүүлдэг. Герман, Франц зэрэг орнуудад ч мөн энэ тухай хуульчлагдсан байдаг байна. Иймд захиргааны хэргийн шүүх шийдвэр гаргахдаа хэрэгжүүлэх арга замыг тодорхой зааж байх шаардлагатай.

ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх алба, ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын

¹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016 он. №9

² Ханнс-Зайделийн сан, Монгол улсын дээд шүүх. Монгол улсын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ., 2012. 254 дэх тал

төв хамтран явуулсан “Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” судалгааны ажлын явцад ШШГЕГ-ын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 250 шийдвэр гүйцэтгэгчийн 211 шийдвэр гүйцэтгэгч буюу 84.4%-иас захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авч нэгтгэхэд дараах тугамдаж буй асуудлыг гарсан байна.

Хүснэгт 2. Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Тулгамдаж буй асуудал	Шийдвэрлэх арга зам
ШШГБ нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын харьяанд байгаагаас нийтийн эрх зүйн байгууллагуудад холбогдох захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй. Өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэхэд харьяалах дээд шатны байгууллага, яамдаар уламжлуулах гэх мэт.	Захиргааны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих чиг үүргийг анхан шатны шүүхэд шилжүүлэх шаардлагатай. Дэлхийн улс орнуудад захиргааны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэгч нь анхан шатны шүүх байх бөгөөд, шүүхээс сануулах, торгууль оногдуулах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Торгуулийн систем нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл хугацаанд оногдуулах эрх олгогдсон байдаг байна.
Эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох талаар хуульд нарийвчилсан зохицуулалт алга	Захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хэрхэн биелүүлж, хариуцлага тооцохыг хуульд нарийвчлан тусгах
Компанийн үүсгэн байгуулагчид ажилд эгүүлэн томилох шийдвэрийг биелүүлэхгүй байна	
Төсөвт байгууллагаас төлбөр гаргуулахад хүндрэлтэй	

Мөн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дийлэнхийг явуулдаг Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн зарим шийдвэр гүйцэтгэгчээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг тодруулсан бөгөөд түүнээс дурдвал:

- Төлбөр төлөгч буюу хариуцагч нь ихэнхдээ төрийн өндөр албан тушаалтан байдаг тул албадан гүйцэтгэх ажиллагаанд саад учруулдаг, биелүүлдэггүй, байгууллага, газар, хэлтэс хоорондоо шидэлцдэг;

- Газрын маргаантай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тухайн газарт нэгэнт баригдсан үл хөдлөх эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тал дээр талууд тохиролцдоггүй;

- Ажилд эргүүлэн томилох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тухайн албан тушаалд томилогдсон байгаа алба хаагчийн асуудлыг шийдвэрлэх хүртэл хүлээлгэх, эсвэл дахин нэг хүнийг албан тушаалаас үндэслэлгүй халах, дүйцэх албан тушаалд томилуулах асуудалд тохиролцохгүй байх, хэлбэрийн төдий биелүүлэх (томилсон ч хэд хоногийн

дараа дахин халах), намын харьяаллаар талцаж ажилд нь томилохгүй байх зэрэг болно.

Үүнээс үзэхэд захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хариуцагч болох төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй, эсхүл биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж, тухайлбал: төрийн албанаас хууль бусаар халагдсан албан хаагчийг урьд эрхэлж байсан албан тушаалд нь эгүүлэн тогтоосон, хууль бусаар явагдсан тендерийг хүчингүй болгож, уг тендерийг дахин зарлах, үнэлэхийг даалгасан, хэргийн нөхцөл байдлыг дахин шалгаж шинээр захиргааны акт гаргах хүртэл тухайн маргаан бүхий захиргааны актыг түдгэлзүүлсэн зэрэг шүүхийн шийдвэрийг илүүтэйгээр хэрэгжүүлэхгүй уландаа гишгэх байдал нийгэмд байсаар байна.

Аливаа хэрэг, маргааныг үүсэхээс нь өмнө эцэслэн шийдвэрлэх хүртэл, бас шийдсэний дараа ч ихээхэн ажил ундардаг нь тодорхой. Тэгвэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг энэ мэтчилэн хэрэгжүүлэхгүй байх нь эрх зүйт төрд байж боломгүй үзэгдэл юм.

Үндсэн хууль болон бусад хуулиар хамгаалагдсан, эдийн засгийн хувьд оршихуйн үндэс болсон хувийн өмчид хүртэл шүүхийн шийдвэрээр “халдах” ядвал байдаг хэдий ч хэн ч цочирддоггүй. Гэтэл өмчилж боломгүй тэрхүү албан тушаалын эрх мэдэлд халдсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх шалтгаан нөхцөл юунд байна вэ. Элдэв дүрэм журам, тушаал, шийдвэр гаргаж, түүнийгээ мөрдөхийг шаарддаг, магадгүй эс биелүүлсэн тохиолдолд хариуцлага хүртэл хүлээлгэдэг атлаа өөрт нь чиглэсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг зөвтгөх арга байхгүй.

Энэ бүхний шалтгаан нь “объектив” гэхээс илүүтэй ердөө л “субъектив” хүчин зүйл. Өөрийнх нь гаргасан шийдвэрийг шүүх хүчингүй болгосонд эгдүүцэж, захиргааны шинэ акт гаргахыг даалгах байдлаар “албан тушаалын” эрх хэмжээнд нь халдсанд бухимдаж, нөгөө талаас нэхэмжлэгч /төлбөр авагч/-д дийлдсэндээ шаралхаж, эцэст нь гарсан шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байх, хэлбэрийн төдий биелүүлэх байдлаар иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бодитоор сэргээхгүй байгаа нь захиргааны байгууллага, албан тушаалтны бодит дүр зураг юм.

Шүүхийн шийдвэр тухайн маргааны хувьд эрх зүйн дээд хүчин чадалтай, эцсийн бөгөөд заавал биелэгддэг байх шинжийг өөртөө агуулдаг¹ тул хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчид сайн дураар биелүүлэхгүй байх тохиолдолд албадан гүйцэтгэх ажиллагаа явагдах шаардлага гардаг боловч төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд энэхүү албадлагыг хэрэглэж тэдгээрээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг шаардана гэдэг нилээд хүндрэл бэрхшээлтэй асуудлын нэг болжээ.

¹ Б.Алтангэрэл, Б.Эрдэнэ-Очир нар. Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2015. 53 дахь тал

Түүнчлэн орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартаа харьяалагддаг, өөрөөр хэлбэл удирдлага зохион байгуулалт, боловсон хүчний бодлого, цалин хөлс гэх зэргээр тухайн нутаг дэвсгэрийн захиргааны байгууллагаас хамааралгүй боловч өнөөдрийн байдлаар жишээ нь аймгийн Засаг даргад шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг албадна гэдэг шийдвэр гүйцэтгэгч нарын хувьд зүйрлэхэд “муурын сахлаар оролдсон хулганатай адил” байгааг нуух юун.

Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэр, буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг төрөөс барагдуулж, буруутай албан тушаалтнаас нөхөн гаргуулахаар хуулийн зохицуулалтыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар 2008-2015 онд төсөвт байгууллагад холбогдох 41.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгох ажиллагаа явагдсаны 8.1 тэрбум төгрөгийг 465 иргэнд олгожээ.¹

Эрх бүхий албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас ажлаас халагдсан иргэний албан тушаалд шинээр томилогдсон ажилтанд цалин олгох мөн эгүүлэн томилогдсон ажилтанд ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн төлж, өөрөөр хэлбэл нэг албан тушаалд 2 цалинг олгон цалингийн давхардал үүсгэж улсын төсөвт хохирол учруулж байна.

Хуульд зааснаар “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах” бүрэн эрхийг Төрийн албаны зөвлөлд олгосон ч төсөвт учруулсан хохирол нөхөн төлөгдөөгүй ба гэм буруутай эрх бүхий албан тушаалтанд өөрт нь санхүүгийн хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бүрдүүлснээр хууль бус үйлдлийг тодорхой хэмжээгээр хязгаарлах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шүүх эрх мэдлийн байгууллага гаргасан шийдвэртээ хяналт тавих, гэм буруутай эрх бүхий албан тушаалтанд 960.0 мянган төгрөгөөс 1.9 сая төгрөгийн мөнгөн торгуулийн арга хэмжээ оногдуулах хариуцлагын тогтолцоо бий болсон.

ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хуулийн 172 дугаар зүйлд “...шүүхийн шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд торгууль оногдуулсны дараа шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол дахин торгууль оногдуулна”² гэж хуульчилсан байдаг нь манай улсад нэвтрүүлж болохоор дэвшилттэй практик гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга, хэлбэрийг боловсронгуй болголоо ч ажиллагааг гүйцэтгэж буй этгээдийн ажиллах орчин бүрдээгүй, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдаагүй тохиолдолд хуулийн хэрэгжилтийг хангах, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй. Иймд шийдвэр гүйцэтгэгчийг үзүүлэлт, хурд өндөртэй техник, тоног төхөөрөмжөөр хангах, ажиллагаа явуулахад шаардагдах тээврийн хэрэгслээр хангаж, ажиллах орчныг бүрдүүлэн ажилласнаар үйл ажиллагаа шуурхай явагдах боломж бүрдэнэ.

¹ Ч. Өнөрцэцэг. Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл-// Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал онол, арга зүйн сэтгүүл. УБ., 2016. №2

² Das Verwaltungsgerichtsgesetz (Deutschland) 1960.

Дүгнэлт

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь Иргэний болон Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас онцлог бүхий ялгаатайгаар зохицуулагдаж, хэрэгждэг харилцаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн тогтолцооны гол хэсэг бөгөөд Захиргааны шүүхийн үндсэн зорилго нь хууль бус захиргааны үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бөгөөд энэхүү зорилгыг хэрэгжүүлэх бие даасан тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа байна.

Санал

Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар дараах саналыг дэвшүүлж байна.

1. Захиргааны шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих чиг үүргийг анхан шатны шүүхэд шилжүүлэх;

2. Мөнгөн торгууль оногдуулаад тогтоосон хугацаа өнгөрсний дараа шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа тохиолдолд дахин торгуулийн арга хэмжээ оногдуулах;

3. Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нь хандаж албан тушаалаас нь чөлөөлөх зэрэг хариуцлагын тогтолцоог бий болгох.